



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.14.7, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр, 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын хөтөлбөрт 2023-2024 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Элсэлтийн үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сургалт, цахим шилжилтийн газрын захирал (Н.Эрдэнэхүү), Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга (М.Эрдэнэтүяа), Мэдээллийн технологийн төвийн дарга (Р.Төрбат), бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.
3. ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2023-2024 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэх журам, сургалтын хөтөлбөрүүдийг сурталчилах, маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулахыг Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга (М.Эрдэнэтүяа), Захирлын ажлын албаны дарга (Н.Ганзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Т.НАМНАН



367040580

ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний
өдрийн А/110 дугаар тушаалын хавсралт

	ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ ШУТИС-СҮ-ЖУ11	Эхний хэвлэлт Өөрчилсөн огноо Өөрчлөлтийн дугаар	1991.05.01 2023.03.31 34
---	---	---	--------------------------------

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ
(2023-2024 оны хичээлийн жил)

Боловсруулсан:

СУРГАЛТЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН АЛБА

Хянаасан:

СУРГАЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ИЙН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ИЙН ЗАХИРАЛ



АГУУЛГА

АГУУЛГА.....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....	4
ЗУРГАА. ЭЛСЭЛТИЙН КОМИСС	6
ДОЛОО. БҮРТГҮҮЛЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА	6
НАЙМ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ.....	7
ЕС. УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ	8
АРАВ. ОНООНЫ ЖАГСААЛТ, ЭРЭМБЭЛЭЛТ	9
АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨР СОНГОЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ	10
АРВАН ХОЁР. ЭЛСЭГЧИЙН БҮРТГЭЛ.....	10
АРВАН ГУРАВ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ	11
АРВАН ДӨРӨВ. БУСАД.....	12
ХАВСРАЛТ 1. БАКАЛАВРЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ	13
ХАВСРАЛТ 2. ХАМТАРСАН ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ	21
ХАВСРАЛТ 3. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ	24
ХАВСРАЛТ 4. БАЙРШИЛ, ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ.....	25



3

ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний
өдрийн А/110 дугаар тушаалын хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэн суралцахаар хүсэлт гаргагч, элсэлтийн ажлыг удирдан зохион байгуулах элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- Боловсрол, шинжлэх ухааны яамнаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох стандартад нийцүүлэн сургуулийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтаан ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт намрын улиралд суралцагч элсүүлнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- Энэхүү журам нь ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2023-2024 оны хичээлийн жилийн намрын улиралд суралцагч бүртгэх, ур чадварын шалгалт авах, оноогоор эрэмбэлэх, мэргэжил сонголт хийлгэх, баталгаажуулах, элсүүлэх үйл явцыг тус тус хамарна.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 10-р сарын 06-ний өдрийн А/347 тоот тушаалаар батлагдсан “Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол улсын элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээтэй дүйцүүлэх журам”;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 09-р сарын 09-ний өдрийн А/343 тоот “Мэргэжлийн чиглэл/хөтөлбөр/-ээр сургалт эрхлэх зөвшөөрөл олгох” тухай тушаал;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/540 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”;
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/97 тоот “Босго оноо тогтоох тухай” тушаал;

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- Элсэлтийн ерөнхий шалгалт:** Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх хүсэлтэй бүрэн дунд боловсролтой иргэний монгол хэл бичиг болон бусад хичээлээр эзэмшсэн ерөнхий боловсролын мэдлэг, чадварын түвшнийг тогтоох зорилго бүхий шалгалтыг;
- Бүртгүүлэгч:** Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх хүсэлт гаргасан иргэнийг;
- Элсэгч:** Хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг;
- Элсэлтийн систем:** Элсэлтийн цахим бүртгэлийн системийг;
- Элсэлтийн комисс:** Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;
- Ур чадварын шалгалтын комисс:** Ур чадварын шалгалтыг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;



- 4.7. **Элсэлтийн бүртгэл:** Элсэлтийн веб хуудсанд нэвтрэч хувийн мэдээллийг оруулан, элсэх хүсэлтэй хэд хэдэн хөтөлбөрийг сонгож, цахимаар төлбөр төлж баталгаажуулах үйл явцыг;
- 4.8. **Хөтөлбөр сонголт, баталгаажуулалт:** ШУТИС-ийн тухайн сургалтын хөтөлбөрт тохирох хичээлүүдээр ЭЕШ өгсөн элсэгч босго онооны болзол ханган, онооны жагсаалтын дагуу хөтөлбөр сонгон, баталгаажуулах үйл явцыг;
- 4.9. **Хяналтын тоо:** Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан хөтөлбөрт элсүүлэх суралцагчийн тоог;
- 4.10. **Гадаадын иргэн:** Монгол Улсын иргэний харьяалалгүй буюу гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг;
- 4.11. **Иргэнээр суралцагч:** Дээд боловсролын сургалтын байгууллагын ямар нэг хөтөлбөрт албан ёсоор элсээгүй боловч хичээл сонгон судалж байгаа Монгол Улсын иргэнийг;
- 4.12. Журамд дурдсан ШУТИС-ийн бүрэлдэхүүн, харьяа сургуулийн товчилсон нэрийг хүснэгт 1-д үзүүлснээр хэрэглэнэ.

Хүснэгт 1.

д/д	Сургуулийн нэр	Товчлол
1	Боловсрол, шинжлэх ухааны яам	БШУЯ
2	Элсэлтийн өрөнхий шалгалт	ЭЕШ
3	Шинжлэх ухаан, технологийн их сургууль	ШУТИС
4	Барилга, архитектурын сургууль	БАС
5	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	БүХС
6	Геологи, уул уурхайн сургууль	ГУУС
7	Механик, тээврийн сургууль	МехТС
8	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	МХТС
9	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	ҮТС
10	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	ХШУС
11	Эрчим хүчний сургууль	ЭХС
12	Гадаад хэлний сургууль	ГХС
13	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	ДаТС
14	“Эрдэнэт цогцолбор” дээд сургууль	ЭЦДС
15	Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль	ӨмТДС

ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1. **ШУТИС-ийн Захирал**
 - 5.1.1. Элсэлтийн төв комиссыг байгуулна.
 - 5.1.2. Элсэлтийн комиссын ажлын төлөвлөгөө, төсвийг батална.
 - 5.1.3. Элсэлтийн үйл ажиллагааны явцтай танилцаж санал, зөвлөмж өгнө.
 - 5.1.4. Элсэлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлантай танилцаж үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 5.2. **Элсэлтийн төв комисс**



- 5.2.1. Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.
- 5.2.2. Элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.
- 5.2.3. Ур чадварын шалгалт зохион байгуулах комиссыг байгуулж ажиллуулна.
- 5.2.4. Элсэлтийн маркетингийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
- 5.2.5. Элсэлтийн үеийн өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулна.
- 5.3. Элсэлтийн салбар комисс**
 - 5.3.1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн ДаТС, ШУТИС-ийн харьяа ЭЦДС, ӨМТДС-ийн сургуульд элсэлтийн салбар комисс байгуулж 5.2-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 5.4. Сургалтын бодлого, хөтөлбөрийн алба**
 - 5.4.1. Элсэлтийн журам боловсруулж, баттуулна.
 - 5.4.2. Элсэлтийн төв комиссын бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг боловсруулж баттуулна.
 - 5.4.3. Элсэлтийн салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж хамтран ажиллана.
 - 5.4.4. Элсэлттэй холбоотой үндсэн үйл ажиллагааг зохицуулах, шаардлагатай бичиг баримтууд боловсруулах, оролцогч талуудыг мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.
 - 5.4.5. Элсэлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайланг бэлтгэж захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 5.5. Мэдээллийн технологийн төв**
 - 5.5.1. Элсэлтийн веб сайтад холбогдох мэдээллийг оруулах, шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ.
 - 5.5.2. Бүртгүүлэгчдийг мэдээллээр хангах гар утасны аппликешн программд бэлтгэсэн мэдээллийг оруулах, шинэчлэх ажлыг хариуцна.
 - 5.5.3. Цахим элсэлтийн бүртгэл, хуваарь сонголтын программ хангамжийг шинэчлэн хөгжүүлнэ.
 - 5.5.4. Цахим элсэлтийн программ хангамжийн найдвартай, хэвийн ажиллагааг хангана.
 - 5.5.5. Сервер, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангана.
- 5.6. Захирлын ажлын алба**
 - 5.6.1. Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой сурталчилгааны материал бэлтгэх, хөтөлбөрүүдийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр сурталчлах ажлыг зохион байгуулна.
 - 5.6.2. Бүрэлдэхүүн, харьяа сургуулиудын элсэлтийн сурталчилгааны ажилд дэмжлэг үзүүлнэ.
 - 5.6.3. Элсэлтийн маркетингийн үйл ажиллагааг тайлagnана.
- 5.7. Эрүүл мэндийн төв**
 - 5.7.1. Шинээр элсэгчдийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулна.
- 5.8. Бүрэлдэхүүн, харьяа сургууль**
 - 5.8.1. Хөтөлбөрийн талаарх цахим болон хэвлэмэл танилцуулга материал боловсруулж түгээх, мөн бусад хэлбэрээр хөтөлбөр сурталчлах ажлыг зохион байгуулна.



- 5.8.2. Хөтөлбөр хариуцаж байгаа салбар, тэнхимүүд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдэд элсэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор тусгайллан ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ба энэ үйл ажиллагаанд багшлах бүрэлдэхүүнийг татан оролцуулна.
- 5.8.3. Шинэ элсэгчтэй суралцах гэрээ байгуулан зөвлөх багш, сургалтын албаар дамжуулан сургалтын үйл ажиллагааг танилцуулж хичээл сонголтыг зохион байгуулна.
- 5.9. **Элсэгч**
 - 5.9.1. ШУТИС-ийн элсэлтийн журам, элсэгчдэд зориулсан бусад материалтай танилцаж элсэлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар мэдээлэл авна.
 - 5.9.2. Элсэлтийн бүртгэлийн системд хувийн мэдээллээ үнэн зөв оруулж, бүртгүүлнэ.
 - 5.9.3. Босго онооны болзол хангасан бүртгүүлэгч цахим элсэлтийн системээр дамжуулан хөтөлбөр сонголт хийж, заасан хугацаанд баталгаажуулна.
 - 5.9.4. Хөтөлбөр баталгаажуулалт хийсэн элсэгчид сонгосон хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бүрэлдэхүүн эсвэл харьяа сургуультай суралцах гэрээг байгуулна.

ЗУРГАА. ЭЛСЭЛТИЙН КОМИСС

- 6.1. ШУТИС-ийн элсэлтийн төв комисс болон ур чадварын шалгалтын комиссыг ШУТИС-ийн захирлын тушаалаар, харьяа сургуулийн элсэлтийн салбар комиссыг тухайн сургуулийн захирлын тушаалаар тус тус батална.
- 6.2. Элсэлтийн төв комиссын дарга нь элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллах бөгөөд тухайн журмаар зохицуулагдаагүй асуудлыг бүрэлдэхүүн/харьяа сургуулийн саналыг үндэслэн комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

ДОЛОО. БҮРТГҮҮЛЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

- 7.1. ШУТИС-ийн бакалаврын сургалтад элсэн суралцах хүсэлтэй, Элсэлтийн Ерөнхий Шалгалт (ЭЕШ) өгсөн бүртгүүлэгч дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
 - 7.1.1. Бүрэн дунд ба түүнээс дээш тувшиний боловсролтой байх;
 - 7.1.2. ШУТИС-ийн элсэлт авах хөтөлбөр/мэргэжилд харгалзах суурь хичээлийн аль нэг, мөн дагалдах хичээлийн аль нэгээр ЭЕШ өгч элсэлтийн журамд заасан босго онооны болзлыг хангасан байх;
 - 7.1.3. Ур чадварын шалгалт тооцох хөтөлбөрт бүртгүүлэгч нь ШУТИС-иас зохион байгуулсан ур чадварын шалгалтыг өгч, босго онооны шаардлагыг хангасан байх;
 - 7.1.4. Бүртгүүлэгчийн ЭЕШ-ын батламж нь шалгалт өгсөн өдрөөс хойш 2 жил 8 сарын хугацаанд хүчинтэй байх нөхцөлийг хангасан байх.
- 7.2. ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцах хүсэлтэй, дараах шалгууруудын аль нэгийг хангасан бүртгүүлэгч ЭЕШ өгөхгүйгээр шууд элсэж болно. Үүнд:
 - 7.2.1. Аль нэг их, дээд сургуульд бакалаврын боловсрол эзэмшсэн иргэн;
 - 7.2.2. ШУТИС-д элсэлт авах бакалаврын хөтөлбөрийн чиглэлээр техникийн боловсролын дипломтой иргэн;



- 7.2.3. ШУТИС-д элсэлт авах бакалаврын хөтөлбөрийн дагуу инженер, технологийн чиглэлийн шаталсан сургалттай сургуулийг төгссөн иргэн;
- 7.2.4. Улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг олон улсын элсэлтийн шалгалт (SAT гэх мэт) өгч, дүн оноогоо Боловсролын Үнэлгээний Төв(БҮТ)-өөр дүйцүүлэн тооцуулж батламж авсан, дүйцүүлсэн оноо нь ШУТИС-ийн элсэлтийн босго онооны болзол хангасан иргэн;
- 7.2.5. ШУТИС-д элсэлт авах бакалаврын хөтөлбөрийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн;
- 7.2.6. Гадаадын аль нэг улсын их, дээд сургуульд суралцаж байгаад ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт шилжин суралцах иргэн;
- 7.3. Журмын 7.2 заалтын дагуу хувиараа эсвэл байгууллагын захиалгаар ШУТИС-д элсэн суралцах хүсэлт гаргасан бүртгүүлэгчийг бакалаврын хөтөлбөрийн өдрийн, цагийн /эчнээ/ сургалтад танхим, цахим эсвэл хосолсон хэлбэрээр хамруулах эсэхийг бүртгүүлэгчдийн тоог харгалзан хөтөлбөр хэрэгжүүлэх салбар, тэнхимиийн саналд үндэслэн шийдвэрлэнэ.
- 7.4. Журмын 7.2.1-7.2.3 болон 7.2.6 заалтын дагуу элсэн суралцах иргэнийг бакалаврын сургалтын сонгосон хөтөлбөрт шууд элсүүлэх ба өмнө эзэмшсэн боловсролын диплом эсвэл суралцсан хугацааны дүнгийн тодорхойлолтыг үндэслэн "ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам"-ын дагуу боломжит хичээлүүдийг дүйцүүлэн тооцно.
- 7.5. Журмын 7.2.4 заалтын болзол хангасан бүртгүүлэгчийг олон улсын шалгалтын дүйцүүлсэн оноог нь үндэслэн бүртгэж, ЭЕШ өгсөн элсэгчдийн хамт эрэмбэлэн хөтөлбөр сонгуулна.
- 7.6. Журмын 7.2.5 заалтын дагуу элсэх бүртгүүлэгчийг ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгал төлсөн баримт, өргөдөл болон эсээ (бүртгүүлэгч өөрийн суралцах бэлтгэл хангасан байдал, авьяас чадвар, туршилага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлсэн байна) бичсэн байдал зэргийг үндэслэн элсүүлнэ.
- 7.7. ШУТИС-ийн болон ДаТС-ийн харьяа ахлах сургуулийг төгссөн, ЭЕШ-ын оноо нь ШУТИС-ийн босго онооны болзол хангасан төгсөгчдийг онооны жагсаалтын дагуу хөтөлбөр сонгуулж, ШУТИС-д элсүүлэн суралцуулна.
- 7.8. ШУТИС-ийн Коосэн Технологийн коллеж төгссөн бүртгүүлэгчдийг 7.2.3 заалтын дагуу бакалаврын хөтөлбөрт шууд элсүүлнэ.
- 7.9. MCYT-ийн төгсөгч нь ЭЕШ өгч ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт тавигдах босго онооны болзол хангасан тохиолдолд элсэн суралцах боломжтой.
- 7.10. ШУТИС-д бакалаврын хөтөлбөрт суралцахаар хүсэлт гаргасан гадаадын иргэний асуудлыг тусдаа журмаар зохицуулна.

НАЙМ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

- 8.1. 2023-2024 оны хичээлийн жилийн намрын улирлын элсэлтийн бүртгэлийг БҮТ-өөс зохион байгуулах ЭЕШ-ын хугацааны төлөвлөлтөөс хамаарч элсэлтийн комиссоос гаргасан хуваарийн дагуу явуулна. Бүртгэлийн хуваарийг элсэлтийн веб сайтаар дамжуулан нийтэд түгээнэ.
- 8.2. ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрийн элсэлтийн бүртгэлийг www.elselt.edu.mn хаягтай веб сайтаар дамжуулан улс орон даяар цахим хэлбэрээр зохион байгуулна.



- 8.3. Бүртгүүлэгч нь элсэлтийн веб хуудсанд нэвтрэхдээ БҮТ-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтэрнэ. Бүртгүүлэгч ЭЕШ-ыг өмнөх жилүүдэд өгсөн бол элсэлтийн комисст хүсэлт гаргаж бүртгэлд хамрагдана.
- 8.4. Бүртгүүлэгч элсэлтийн системд бүртгүүлэхдээ анкет бөглөж шаардлагатай хувийн мэдээллийг оруулан, ШУТИС-ийн бүрэлдэхүүн БАС, БуХС, ГУУС, МөхТС, МХТС, ЙТС, ХШУС, ЭХС, ГХС, ДаТС, ШУТИС-ийн харьяа ЭЦДС, ӨмТДС-ийн хэрэгжүүлж байгаа үндсэн болон гадаад, дотоодын хамтарсан хөтөлбөрүүдээс урьдчилсан байдлаар сонголт хийхээс гадна ШУТИС-ийн элсэлтийн журамтай заавал танилцаж, зүйл заалтуудыг хүлээн зөвшөөрсөн эсэхээ баталгаажуулсан байна.
- 8.5. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд шаардлагатай мэдээллээ үнэн зөв оруулан, бүртгэлийн хураамжийг цахимаар төлж баталгаажуулснаар бүртгэл хүчин төгөлдөр болно.
- 8.6. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах ба алдаатай, буруу мэдээлэл оруулснаас үүсэх хариуцлагыг ШУТИС хүлээхгүй.
- 8.7. Элсэлтийн бүртгэлийн хураамжийг ШУТИС-ийн элсэлтийн төв комисс баталж, тухайн хичээлийн жилд мөрдөх ба буцаан олголт хийхгүй.
- 8.8. Хавсралт 1-д заасан бакалаврын үндсэн хөтөлбөрүүдийг тухайн бүрэлдэхүүн, харьяа сургууль хариуцан хэрэгжүүлэх ба элсэгч энд заасан сургалтын хугацаанд, харгалзах кредитийг цуглувж төгсөх болзол хангана.
- 8.9. Хавсралт 2-д заасан гадаадын их, дээд сургуультай хамтарсан хөтөлбөрийн эхний 2 эсвэл 3 жилийн сургалтыг тухайн бүрэлдэхүүн сургууль, сүүлийн жилүүдийн сургалтыг тухайн улсын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нэгж тус тус хариуцах ба төгсөх болзол хангасан суралцагчид 2 сургуулийн бакалаврын зэрэг, диплом олгоно.
- 8.10. Хавсралт 2-д заасан дотоодын их, дээд сургуультай хамтарсан хөтөлбөрийн эхний 1 эсвэл 2 жилийн сургалтыг тухайн орон нутагт байрлах сургууль, сүүлийн жилүүдийн сургалтыг Улаанбаатар хотод байрлах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бүрэлдэхүүн сургууль тус тус хариуцах ба төгсөх болзол хангасан суралцагчид Улаанбаатар хотын бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын зэрэг, диплом олгоно.
- 8.11. ХШУС-ийн хэрэгжүүлж байгаа Герман хэлээр явагдах "Статистик" хөтөлбөрт эхний 2 жилийн сургалтаар Герман хэлийг гүнзгийрүүлэн судлахаас гадна 1, 2-р курсын цөм суурь хичээлүүд Герман хэлээр заагдана. Хөтөлбөрт суралцагч 1 эсвэл 2-р курс төгссөний дараа Герман улсын их дээд сургуульд хувиараа элсэх суралцах хүсэлт гаргаж болно. Мөн дотооддоо ШУТИС-ийн дурын бакалаврын хөтөлбөрт 3-р курсээс үргэлжлүүлэн суралцаж болно.

ЕС. УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ

- 9.1. Дагалдах хичээлд ур чадварын шалгалт тооцох хөтөлбөрүүдийн шалгалтыг элсэлтийн бүртгэл дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан томилогдсон комисс зохион байгуулж, шалгалтын дүнг бүртгэлийн цахим системд оруулна.
- 9.2. Ур чадварын шалгалтыг 0-100 оноогоор үнэлэх ба оноог хүснэгт 2-д үзүүлсэн аргачлалаар хэмжээст оноонд шилжүүлнэ.
- 9.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадад эхний 5 байрт шалгарсан бүртгүүлэгчийн ур чадварын шалгалтыг оноог шууд тооцно. Ур чадварын

ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний
өдрийн А/110 дугаар тушаалын хавсралт



шалгалтын оноог дүйцүүлэн тооцох олимпиадын мэдээллийг элсэлтийн комисс тодорхойлж, элсэлтийн веб сайтаар нийтэд түгээнэ.

Хүснэгт 2. Шалгалтын оноог хэмжээст оноонд шилжүүлэх аргачлал

№	Үсгэн үнэлгээ	Шалгалтын оноо	Хэмжээст оноо
1	A+	95-100	760-800
2	A	90-94	720-759
3	B+	85-89	680-719
4	B	80-84	640-679
5	C+	75-79	600-639
6	C	70-74	560-599
7	D+	65-69	520-559
8	D	60-64	480-519
9	F	0-59	200-479

АРАВ. ОНООНЫ ЖАГСААЛТ, ЭРЭМБЭЛЭЛТ

- Элсэлтийн бүртгэл хаагдсаны дараа бүртгэлээ баталгаажуулсан бүртгүүлэгчдийн ЭЕШ-ын оноог БҮТ-ийн серверээс ШУТИС-ийн элсэлтийн системд татаж, суурь ба дагалдах (Зарим хөтөлбөрт ур чадварын шалгалт) хичээлийн онооноос бүртгүүлэгчдийн нийлбэр оноог тооцоолж, хөтөлбөр бүрээр босго оноотой харьцуулан эрэмбэ үүсгэнэ.
- Суурь шалгалтад тооцох 2 хичээлийн (Зарим хөтөлбөрт 1 хичээл) хамгийн өндөр оноотой хичээлийн оноог нийлбэр онооны 70%, дагалдах хичээлийн шалгалтад тооцох 2 хичээлийн (Зарим хөтөлбөрт 1 хичээл) хамгийн өндөр оноотой хичээлийн оноог нийлбэр онооны 30%-д тус тус тооцож нийлбэр оноог гаргана.
- ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрүүдээс зөвхөн тэргүүлэх чиглэлийн болон эрэлттэй чиглэлд хамаарах хөтөлбөрүүдийн хувьд суурь шалгалтад тооцуулаагүй хичээлийг дагалдах хичээлийн шалгалтад тооцож болно. Эрэлттэй болон тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдийн мэдээллийг хавсралт 1-д ялган тэмдэглэсэн болно.
- Эрэмбэлэх үед бүртгүүлэгчийн нийлбэр оноо тэнцвэл ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг, гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог тус тус харгалзана. ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг 10.2 заалтын дагуу тооцно.
- ШУТИС-д элсэлт авах үндсэн хөтөлбөрүүдэд харгалзах босго оноог хавсралт 1, гадаад, дотоодын их дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрүүдэд харгалзах босго оноог хавсралт 2-д заасны дагуу тооцно. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй харьяа сургуулиудын хувьд БШУЯ-наас баталсан босго оноог(2023-2024 оны намрын улирлын элсэгчдэд 410-аас доошгүй байх) баримтална.



АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨР СОНГОЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ

- 11.1. Хөтөлбөр сонголтын үйл ажиллагааг орон даяар www.elselt.edu.mn веб сайтаар дамжуулан цахим хэлбэрээр явуулна.
- 11.2. Хөтөлбөр сонгох зарчим, үйл ажиллагааны дараалал болон хөтөлбөр сонголт эхлэх, дуусах хугацааг элсэлтийн төв комисс тодорхойлж, мэдээллийг элсэлтийн веб сайтаар дамжуулан албан ёсоор нийтэд урьдчилан хүргэнэ.
- 11.3. Бүртгүүлэгч ЭЕШ өгсөн харьяллаас үл хамааран хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан тохиолдолд тухайн хөтөлбөрийг сонгох эрхтэй болно. Хяналтын тоонд багтсан эсэхээ онооны жагсаалт гарсны дараа элсэлтийн системд хандаж шалгана.
- 11.4. Хэд хэдэн хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч зөвхөн нэг л хөтөлбөр сонгоно. Ингэснээр хяналтын тоонд багтсан боловч сонголт хийгээгүй бусад хөтөлбөрийн жагсаалтаас бүртгүүлэгчийн нэр хасагдаж хяналтын тоонд шинээр багтсан бүртгүүлэгч хөтөлбөр сонгох эрхтэй болно.
- 11.5. Бүртгүүлэгч хөтөлбөр сонголт эхэлснээс хойш элсэлтийн комиссын тогтоосон хугацаанд хөтөлбөрөө сонгон, 1 багц цагийн төлбөр төлж баталгаажуулалт хийнэ. Хөтөлбөр баталгаажуулалт хийсэн тохиолдолд “ШУТИС-д суралцах цахим эрхийн бичиг” олгоно.
- 11.6. Хөтөлбөр сонголтыг баталгаажуулсан 1 багц цагийн төлбөрийг элсэгчийн сургалтын төлбөрт тооцно. Элсэгч баталгаажуулсан хөтөлбөрөө цуцлах тохиолдолд дараагийн бүртгүүлэгчийн хөтөлбөр сонгох боломжийг хаасан үндэслэлээр баталгаажуулалтын төлбөрийн буцаан олгохгүй.
- 11.7. Элсэлтийн комиссын тогтоосон хугацаанд хөтөлбөр сонголт, баталгаажуулалт хийгээгүй тохиолдолд хөтөлбөр сонголтоос татгалзсан гэж үзэж жагсаалтын дараагийн бүртгүүлэгчид хөтөлбөр сонгох эрх шилжинэ.
- 11.8. Олон улсын болон улсын чанартай олимпиадад амжилттай оролцож эхний 5 байр байр эзэлсэн бүртгүүлэгчид тухайн хөтөлбөрийн босго онооны болзол хангасан тохиолдолд элсэлтийн комиссын шийдвэрийг үндэслэн давуу эрхтэйгээр хөтөлбөр сонголт хийлгэхээс гадна эхний жилд сургалтын төлбөрийн тодорхой хувийн тэтгэлэг олгоно.
- 11.9. ШУТИС-ийн хэрэгжүүлж байгаа зарим хөтөлбөрөөр орон нутагт ажлын байрны эрэлт хэрэгцээ үүсэж, суралцааг элсүүлэх албан захиалга ирсэн тохиолдолд тухайн орон нутгийн харьялал бүхий, босго онооны болзол хангасан бүртгүүлэгчийг ШУТИС-д элсүүлэн суралцуулах эсэх асуудлыг элсэлтийн төв комисс шийдвэрлэнэ.

АРВАН ХОЁР. ЭЛСЭГЧИЙН БҮРТГЭЛ

- 12.1. Цахим суралцах эрхийн бичиг авсан элсэгчид 2023 оны 08 дугаар сарын 14-нөөс 31-ны хооронд www.elselt.edu.mn хаягаар бакалаврын элсэлтийн системд нэвтэрч элсэгчийн анкет бөглөн оюутны код, нууц үг авна.
- 12.2. Оюутны код, нууц үгээ ашиглан <https://student.must.edu.mn/> хаягаар оюутны вебд нэвтэрч зөвлөх багшийн мэдээлэл авахаас гадна хичээл сонголт хийх заавар, зөвлөмжтэй танилцана. Мөн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа сургуулийн сургалтын албанад өөрийн биеэр очиж суралцах гэрээ байгуулна.

ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний
өдрийн А/110 дугаар тушаалын хавсралт



- 12.3. Журмын 12.1-д заасан хугацаанд бүртгүүлж, суралцах гэрээ байгуулаагүй элсэгчдийг ШУТИС-д суралцахаас татгалзсан гэж үзэж элсэх эрхийг нь хүчингүйд тооцно.

АРВАН ГУРАВ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ

- 13.1. 2023-2024 оны элсэгчдийн дунд “ШУТИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг” олгох сонгон шалгаруулалт явуулж, шаардлага хангасан элсэгчдэд 1 удаа 30 хүртэл багц цагийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.
- 13.2. ШУТИС-д элссэн авьяаслаг элсэгчдэд дараах нөхцөлүүдэд элссэн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно. Үүнд:
 - 13.2.1. Олон улсын олимпиадын 1-3-р байр эзэлсэн бол эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг олгоно.
 - 13.2.2. Техник-технологийн улсын олимпиадын 1-р байр эзэлсэн бол эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг олгоно.
 - 13.2.3. Техник-технологийн улсын олимпиадын 2, 3-р байр эзэлсэн бол эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн 75 хувийн тэтгэлэг олгоно.
 - 13.2.4. Техник-технологийн улсын олимпиадын 4, 5-р байр эзэлсэн бол эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэг олгоно.
 - 13.2.5. Мэргэжлийн улсын олимпиадын 1-5 дугаар байр эзэлсэн элсэгчид эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэг олгоно.
 - 13.2.6. ШУТИС-ийн харьяа ахлах сургууль төгссөн элсэгч суурь болон дагалдах хичээлд тооцуулсан хичээл тус бүрд 650 ба түүнээс дээш оноо авсан бол оноог харгалзан эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн (50-100) хувьтай тэнцэх тэтгэлэг олгоно.
 - 13.2.7. Элсэгч суурь болон дагалдах хичээлд тооцуулсан хичээл тус бүрд 700-750 оноо авсан бол эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн 50 хувь, 751-775 оноо авсан бол эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн 75 хувь, 776-800 оноо авсан бол эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн 100 хувьтай тэнцэх тэтгэлэг тус тус олгоно.
 - 13.2.8. Тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргасан элсэгчдийн материалыг комисс хянаж, шаардлага хангасан элсэгчдэд журамд заасан хувь хэмжээгээр тэтгэлэг олгох шийдвэр гарган захирлын тушаалаар баталгаажуулна.
- 13.3. Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын З дугаар хавсралтын 2.1.9 заалтын дагуу ДаТС, ЭЦДС, ӨмТДС-ийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагчид эхний жилийн 30 багц цагийн сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэг олгоно.
- 13.4. ДаТС, ЭЦДС, ӨмТДС-ийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагчид мэргэжил харгалзахгүй жилийн сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний зээлийг боловсролын зээлийн сангаас олгоно.
- 13.5. ДаТС, ЭЦДС, ӨмТДС-ийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагч өмнөх улиралд 2,8 болон түүнээс дээш голч дүнтэй үнэлэгдсэн тохиолдолд сургалтын төлбөрийн зээлийг үргэлжлүүлэн олгоно.
- 13.6. Тэргүүлэх ба эрэлттэй мэргэжлээр бакалаврын үндсэн хөтөлбөрт элсэгчдэд ЭЕШ-ын дундаж оноо 600 болон түүнээс дээш байх тохиолдолд 100 хувийн сургалтын төлбөрийн зээл олгоно.



- 13.7. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр ШУТИС-д бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцагч өмнөх улиралд 2,8 ба түүнээс дээш голч дүнтэй үнэлэгдсэн тохиолдолд сургалтын төлбөрийн зээлийг үргэлжлүүлэн олгоно.
- 13.8. Сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшууллыг давхардуулж олгохгүй.
- 13.9. Элсэгчид суралцах хугацаандаа гаргасан сурлагын амжилтаасаа хамаарч дараах байгууллага, сангийн тэтгэлгүүдэд хамрагдах хүсэлт гаргаж болно. Үүнд:
 - 13.9.1. “Мицубиши” корпорацын нэрэмжит тэтгэлэг (Жил бүрийн 9-10 сар)
 - 13.9.2. “Сүмитомо” корпорацын нэрэмжит тэтгэлэг (Жил бүрийн 3-4 сар)
 - 13.9.3. “ШУТИС-Тоёота” сангийн тэтгэлэг (Жил бүрийн 1-2 сар)
 - 13.9.4. “Санко Сэйки” корпорацын нэрэмжит тэтгэлэг (Жил бүрийн 8-9 сар)
 - 13.9.5. Ажаа Гэгээний нэрэмжит зөв тэтгэлэг (7-р сар)
 - 13.9.6. “ЭН ЭЙ ПИ ГРУПП” ХХК-ийн нэрэмжит тэтгэлэг
 - 13.9.7. Бусад тэтгэлгүүд

АРВАН ДӨРӨВ. БУСАД

- 14.1. ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний 4.2.1-д заасан “Тасралтгүй насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх” стратегийн хүрээнд “Иргэнээр суралцагч”-ыг бүртгэн зэргийн бус сургалтад хамруулж болно.
- 14.2. Иргэнээр суралцагч нь ШУТИС-ийн оюутан, ажиллаж байгаа дотоод, гадаадын иргэн байж болох ба тухайн улиралд заагдах бакалаврын түвшний дурын хичээлд өөрийн сонирхлын дагуу бүртгүүлэн суралцаж болно.
- 14.3. Иргэнээр суралцагч 1 улиралд 6-аас илүүгүй багц цагийн хичээл сонгон танхим, цахим эсвэл хосолсон хэлбэрээр суралцаж болно.
- 14.4. Иргэнээр суралцагчийн сонгосон хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг сургалтын дүрэм, журмын дагуу үнэлж гэрчилгээ олгох ба цаашид зэргийн сургалтад элссэн тохиолдолд тухайн хичээлийг дүйцүүлэн тооцуулж болно.



ХАВСРАЛТ 1. БАКАЛАВРЫН ҮНДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

д/д	Индекс	Хөтөлбөрийн нэр	Тэргүүлэх / Эрэлттэй	Суралцах жил	Цүгпуулах кредит	Суурь хичээл /Аль нэгийг заавал өгсөн байх/		Дагалдах хичээл /Аль нэгийг заавал өгсөн байх/	
						Нэр	Босго оноо	Нэр	Босго оноо

Барилга, архитектурын сургууль

1.	073104	Архитектур	T	5	160	Математик, Физик	480	Ур чадвар	480
2.	073204	Барилгын инженерчлэл	T	4	130	Математик, физик	480	Нийгэм судлал, Англи хэл	480
3.	073209	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	T	4	130	Математик, физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
4.	073205	Гүүрийн инженерчлэл		4	130	Математик, физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
5.	073207	Усны барилга, байгууламж	T	4	130	Математик, физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
6.	073210	Авто замын инженерчлэл	T	4	130	Математик, физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
7.	071205	Хаягдал боловсруулах технологи	T	4	130	Математик, Физик	480	Хими, Англи хэл	440
8.	073201	Усан хангамж, ус цэвэрлэгээ	T	4	130	Математик, физик	480	Нийгэм судлал, Англи хэл	480
9.	073202	Сантехникийн инженерчлэл	Э	4	130	Математик, физик	480	Нийгэм судлал, Англи хэл	480
10.	073203	Халаалт, агаар сэлгэлт, кондиционер	Э	4	130	Математик, физик	480	Нийгэм судлал, Англи хэл	480
11.	078808	Усны нөөц, усжуулалт		4	130	Математик, физик	440	Нийгэм судлал, Англи хэл	400

Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

12.	041201	Санхүү		4	128	Математик	480	Англи хэл, Нийгэм судлал	480
13.	041301	Бизнесийн удирдлага		4	128	Математик	480	Англи хэл	480
14.	041304	Хүний нөөцийн менежмент		4	128	Математик	480	Англи хэл, Нийгэм судлал	480
15.	041401	Маркетинг		4	128	Математик	480	Англи хэл	480
16.	031301	Сэтгэл судлал	Э	4	124	Нийгэм судлал, Математик	480	Монгол хэл, Англи хэл	440



17.	041305	Нийтийн удирдлага		4	121	НИЙГЭМ судлал	480	Англи хэл, Нийгэм судлал	480
18.	041402	Олон нийттэй харилцах ажил		4	124	НИЙГЭМ судлал	480	Монгол хэл, Англи хэл	480
19.	092301	Нийгмийн ажил	Э	4	122	НИЙГЭМ судлал, Англи хэл	480	Монгол хэл, Англи хэл	480
20.	041302	Үйлдвэрлэлийн менежмент		4	125	Математик	480	Англи хэл, Физик	480
21.	041303	Менежмент		4	125	Математик	480	Англи хэл	480
22.	101501	Аялал жуулчлал	Э	4	125	Математик, Монгол хэл	440	НИЙГЭМ судлал, Англи хэл	440
23.	048802	Бизнес шинжлэл, загварчлал		4	127	Математик	480	Англи хэл Физик	480

Геологи, уул уурхайн сургууль

24.	072405	Өрөмдлөгийн инженерчлэл		4	129	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
25.	072406	Газрын тосны инженерчлэл	T	4	130	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
26.	072407	Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл		4	130	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
27.	053201	Геодези	T	4	134	Математик, Физик	480	Газарзүй, Англи хэл	440
28.	073101	Газар зохион байгуулалт		4	130	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
29.	053204	Геологи	T	4	130	Математик, Физик	480	Газарзүй, Англи хэл	440
30.	053205	Гидрогеологи		4	130	Математик, Физик	480	Газарзүй, Англи хэл	440
31.	053207	Геофизик		4	130	Математик, Физик	480	Газарзүй, Англи хэл	440
32.	053209	Ашигт малтмалын эрэл, хайгуул		4	130	Математик, Физик	480	Газарзүй, Англи хэл	440
33.	072401	Уул уурхайн ашиглалтын технологи	T	4	130	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
34.	072402	Уул уурхайн геотехник		4	137	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
35.	072403	Уул уурхайн маркшнейдр		4	130	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
36.	072404	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	T	4	129	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
37.	072901	Уул уурхайн машин тоног төхөөрөмж		4	130	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
38.	072902	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт		3.5	130	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
39.	102201	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Э	4	127	Математик, Монгол хэл	440	НИЙГЭМ судлал, Англи хэл	440



40.	058802	Инженер геологи, геотехник		4	132	Математик Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
41.	072408	Хийн инженерчлэл		4	130	Хими	480	Физик, Англи хэл	440

Гадаад хэлний сургууль

42.	023101	Гадаад хэлний орчуулга		4	125	Англи хэл, Нийгэм судлал	480	Математик, Монгол хэл	480
-----	--------	------------------------	--	---	-----	--------------------------	-----	-----------------------	-----

Механик, тээврийн сургууль

43.	071502	Металлурги, металлын технологи	Т	4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
44.	071507	Машин үйлдвэрлэлийн технологи		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
45.	071510	Металл судлал, технологи		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
46.	071402	Үйлдвэрлэлийн автоматжуулалт	Т	4	138	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
47.	071506	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
48.	073211	Барилга замын машин төхөөрөмж		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
49.	071501	Механик инженерчлэл	Т	4	131	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
50.	071603	Машины электрон систем		4	138	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
51.	078811	Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтын технологи	Э	4	131	Математик, Физик	440	Түүх, Нийгэм судлал	440
52.	041308	Логистик менежмент	Т	4	125	Математик	480	Англи хэл, Физик	480
53.	071601	Авто инженерчлэл		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
54.	071604	Авто хөдөлгүүрийн механик инженерчлэл		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
55.	071605	Нисэх техникийн механик	Т	4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
56.	071606	Авионик	Т	4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440

ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний
өдрийн А/110 дугаарт шаалын хавсралт

57.	104101	Зүтгүүр, зүтгүүрийн аж ахуй	4	126	Математик, Физик	480	ТЕХНОЛОГИИ Англи хэл, Нийгэм судлал	440
58.	104105	Тэмэр замын тээврийн удирдлага, зохион байгуулалт	4	125	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440

Мэдээлэл, холбооны технологийн сургууль

59.	061301	Компьютерын ухаан	4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
60.	061902	Хиймэл оюун ухаан	T	4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
61.	071405	Программ хангамжийн инженерчлэл	T	4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
62.	061201	Компьютерын сүлжээ		4	128	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
63.	061202	Кибер аюулгүй байдал	T	4	128	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
64.	061204	Өгөгдлийн ухаан	T	4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
65.	061303	Мэдээллийн систем		4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
66.	061304	Мэдээллийн технологи	T	4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
67.	071401	Электроникийн инженерчлэл		4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
68.	061203	Мультимедиа технологи		4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
69.	061901	IoT /Зүйлсийн интернэт/ технологи	Э	4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
70.	071407	Мэдээлэл холбооны сүлжээний инженерчлэл		4	128	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
71.	071408	Утасгүй холбооны инженерчлэл	T	4	128	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл
72.	078806	Робот ба хиймэл оюун ухаан		4	125	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл

Үйлдвэрлэлийн технологийн сургууль

73.	051102	Микробиологи	4	123	Биологи, Математик	480	Хими, Англи хэл	440
74.	051202	Биотехнологи	T	4	123	Биологи, Математик	480	Хими, Англи хэл



75.	072102	Хоол зүй, шим судлал	Э	4	120	Математик, Хими	480	Нийгэм судлал, Англи хэл	440
76.	072103	Хүнсний чанар, аюулгүй байдал	Т	4	120	Математик, Хими	480	Нийгэм судлал, Англи хэл	440
77.	021105	Хэвлэлийн график дизайн		4	128	Математик, Англи хэл	440	Ур чадвар	480
78.	021106	График дизайн	Э	4	128	Математик, Англи хэл	440	Ур чадвар	480
79.	021202	Хувцасны дизайн		4	130	Математик, Англи хэл	440	Ур чадвар	480
80.	021203	Үйлдвэрлэлийн дизайн	Э	4	128	Математик, Англи хэл	440	Ур чадвар	440
81.	021204	Интерьер дизайн		4	128	Математик, Англи хэл	440	Ур чадвар	480
82.	072303	Арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи		4	130	Математик, Физик	440	Хими, Англи хэл	440
83.	072304	Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи		4	130	Математик, Физик	440	Хими, Англи хэл	440
84.	082102	Ойн инженерчлэл		4	129	Математик, Физик	440	Биологи, Нийгэм судлал	400
85.	071508	Хүнсний үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж		4	130	Математик, Хими	480	Нийгэм судлал, Англи хэл	440
86.	071509	Хөнгөн үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж		4	130	Математик, Хими	480	Нийгэм судлал, Англи хэл	440
87.	072104	Хүнс үйлдвэрлэлийн технологи	Э	4	123	Математик, Хими	480	Нийгэм судлал, Англи хэл	440
88.	072105	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи		4	123	Математик, Хими	480	Нийгэм судлал, Англи хэл	440
89.	072301	Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт	T	4	130	Математик, Нийгэм судлал	480	Англи хэл Ур чадвар	480
90.	072302	Арьсны боловсруулалтын технологи	T	4	130	Математик, Физик	440	Хими, Англи хэл	440
91.	072203	Хэвлэл, медиа үйлдвэрлэлийн технологи		4	130	Математик, Нийгэм судлал	480	Физик, Англи хэл	440
92.	072204	Мод боловсруулах үйлдвэрлэлийн технологи		4	130	Математик, Нийгэм судлал	480	Физик, Англи хэл	440
Хэрэглээний шинжлэх ухааны сургууль									
93.	054201	Статистик	T	4	127	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440



94.	054201	Статистик (Герман хэлний сургалттай хөтөлбөр)	T	4	127	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
95.	053303	Хэрэглээний физик	T	4	129	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
96.	071201	Хүрээлэн буй орчны инженерчлэл	T	4	127	Хими, Математик	480	Физик, Англи хэл	440
97.	078801	Нано шинжлэх ухаан, инженерчлэл	T	4	130	Хими, Математик	480	Физик, Англи хэл	440
98.	071101	Химийн инженерчлэл	T	4	130	Хими, Математик	480	Физик, Англи хэл	440
99.	071103	Химийн боловсруулалтын технологи		4	130	Хими, Математик	480	Физик, Англи хэл	440
100.	071104	Нүүрсний боловсруулалтын технологи	T	4	130	Хими, Математик	480	Физик, Англи хэл	440
101.	071105	Газрын тосны боловсруулалтын технологи	T	4	130	Хими, Математик	480	Физик, Англи хэл	440
102.	072201	Материал судлал, инженерчлэл		4	131	Математик, Физик	480	Хими, Англи хэл	440


Эрчим хүчний сургууль

103.	071204	Экологийн технологи		4	125	Математик, Физик	480	Хими, Англи хэл	440
104.	071301	Сэргээгдэх эрчим хүч	T	4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
105.	071303	Дулааны цахилгаан станцын инженерчлэл		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
106.	071305	Дулааны процессын автоматжуулалт		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
107.	071306	Үйлдвэр, хотын дулаан хангамж		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
108.	071308	Хөргөлтийн технологи ба кондиционерийн систем		4	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
109.	071304	Цахилгаан системийн автоматжуулалт		3.5	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
110.	078810	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт	T	3.5	129	Математик, Физик	400	Нийгэм судлал, Англи хэл	400
111.	071309	Цахилгааны инженер	T	3.5	130	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440
112.	071310	Цахилгаан хангамж	T	3.5	135	Математик, Физик	480	Нийгэм судлал, Англи хэл	440



Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль

TECHNOLOGY								
1.	041301	Бизнесийн удирдлага		4	128	Математик	410	Англи хэл
2.	041303	Менежмент		4	125	Математик	410	Англи хэл
3.	071502	Металлурги, металлын технологи	T	4	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал
4.	071507	Машин үйлдвэрлэлийн технологи		4	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал
5.	071506	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт		4	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал
6.	073211	Барилга замын машин төхөөрөмж		4	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал
7.	072901	Уул уурхайн машин тоног төхөөрөмж		4	130	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй
8.	072103	Хүнсний чанар, аюулгүй байдал	T	4	120	Математик, Хими	410	Англи хэл, Нийгэм судлал
9.	072104	Хүнс үйлдвэрлэлийн технологи	Э	4	123	Математик, Хими	410	Англи хэл, Нийгэм судлал
10.	072401	Уул уурхайн ашиглалтын технологи	T	4	130	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй
11.	072404	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	T	4	129	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй
12.	073204	Барилгын инженерчлэл	T	4	130	Математик, физик	410	Англи хэл, Нийгэм судлал
13.	073201	Усан хангамж, ус цэвэрлэгээ	T	4	130	Математик, физик	410	Англи хэл, Нийгэм судлал
14.	073203	Халаалт, агаар сэлгэлт, кондиционер	Э	4	130	Математик, физик	410	Англи хэл, Нийгэм судлал
15.	073209	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	T	4	130	Математик, физик	410	Англи хэл, Нийгэм судлал
16.	071303	Дулааны цахилгаан станцын инженерчлэл		4	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал
17.	071309	Цахилгааны инженер	T	3.5	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал
18.	071405	Программ хангамжийн инженерчлэл	T	4	125	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал
19.	071304	Цахилгаан системийн автоматжуулалт		3.5	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал



ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний
өдрийн А/110-дугаар тушаалын хавсралт

20.	072902	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт		3.5	130	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй	410
-----	--------	---	--	-----	-----	------------------	-----	---------------------	-----

ШУТИС-ийн харьяа Орхон аймаг дахь “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль

1.	023101	Гадаад хэлний орчуулга		4	125	Англи хэл, Нийгэм судлал	410	Математик, Монгол хэл	410
2.	041101	Нягтлан бодох бүртгэл		4	120	Математик	410	Нийгэм судлал, Англи хэл	410
3.	041302	Үйлдвэрлэлийн менежмент		4	125	Математик	410	Англи хэл, Физик	410
4.	061304	Мэдээллийн технологи		4	125	Математик, Физик	410	Нийгэм судлал, Англи хэл	410
5.	071304	Цахилгаан системийн автоматжуулалт		3.5	130	Математик, Физик	410	Нийгэм судлал, Англи хэл	410
6.	071502	Металлурги, металлын технологи	T	4	125	Математик, Физик	410	Нийгэм судлал, Англи хэл	410
7.	071601	Авто инженерчлэл	T	4	130	Математик, Физик	410	Нийгэм судлал, Англи хэл	410
8.	072401	Уул уурхайн ашиглалтын технологи	T	4	130	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй	410
9.	072404	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	T	4	129	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй	410
10.	072901	Уул уурхайн машин тоног төхөөрөмж		4	130	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй	410
11.	072902	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт		3.5	130	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй	410

ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль

1.	061304	Мэдээллийн технологи		4	125	Математик, Физик	410	Нийгэм судлал, Англи хэл	410
2.	071309	Цахилгааны инженер	T	3.5	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал	410
3.	072401	Уул уурхайн ашиглалтын технологи	T	4	130	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй	410
4.	072406	Газрын тосны инженерчлэл	T	4	130	Математик, Физик	410	Англи хэл, Газарзүй	410

Тайлбар: Монгол Улсыг хөгжүүлэхэд шаардлагатай дээд боловсролын тэргүүлэх хөтөлбөрийн чиглэлийг “Т”, эрэлттэй хөтөлбөрийн чиглэлийг “Э” гэж тэмдэглэсэн бөгөөд орон нутагт хэрэгжүүлэх, хамтарсан хөтөлбөрүүдэд нэгэн адил хамаарна.



ХАВСРАЛТ 2. ХАМТАРСАН ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

Гадаадын их, дээд сургуультай хамтарсан хөтөлбөрүүд

Д/д	Хамтарсан сургуулийн нэр	Хөтөлбөрийн нэр	Суралцах жил	Цуглуулах кредит	Суурь хичээл /Аль нэгийг заавал өгсэн байх/		Дагалдах хичээл /Аль нэгийг заавал өгсэн байх/	
					Нэр	Босго оноо	Нэр	Босго оноо
1.	БНСҮ, Сөүлийн Шинжлэх ухаан технологийн үндэсний ИС	Бизнесийн удирдлага	2+2	130	Математик	480	Англи хэл	480
2.	ХБНГУ "Фрайбергийн уул уурхайн академи" техникийн ИС	Уул уурхайн ашиглалтын технологи	3+2	111+150	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
3.	БНХАУ, Шандуны Шинжлэх ухаан технологийн ИС	Геодези	2+2	183.5	Математик, Физик	480	Англи хэл, Газарзүй	440
4.	БНСҮ, Сүн Чон Хян ИС	Механик инженерчлэл	2+2	135	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
5.	БНСҮ, Ханбатын үндэсний ИС	Механик инженерчлэл	2+2	132	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
6.	БНСҮ, Сөүлийн Шинжлэх ухаан технологийн үндэсний ИС	Механик инженерчлэл	2+2	132	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
7.	ОХҮ, Мэдээлэл холбооны техникийн ИС	Мэдээлэл холбооны сүлжээний инженерчлэл	2+2	161	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
8.		Утасгүй холбооны инженерчлэл	2+2	161	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
9.	БНСҮ, Сүн Чон Хян ИС	Кибер аюулгүй байдал	2+2	153	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
10.	БНХАУ, ӨМӨЗӨ Аж Үйлдвэрийн ИС	Химийн инженерчлэл	2+2	167	Хими, Математик	480	Физик, Англи хэл	440
11.	БНХАУ, ӨМӨЗӨ Баруун Хойд Политехникийн ИС	Статистик	2+2	166	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
12.	БНХАУ, Нанжин Аж Үйлдвэрийн ИС	Хүрээлэн буй орчны инженерчлэл	2+2	161	Хими, Математик	480	Физик, Англи хэл	440

ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний
өдрийн А/110 дугаар тушаалын хавсралт



13.	БНХАУ, Хойд Хятадын эрчим хүчний ИС	Дулааны цахилгаан станцын инженерчлэл	2+2	163	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
14.		Сэргээгдэх эрчим хүч	2+2	145	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
15.		Цахилгаан хангамж	2+2	161	Математик, Физик	480	Англи хэл, Нийгэм судлал	440
16.	БНХАУ, Шанхайн Шинжлэх ухаан технологийн ИС	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт	2+2	165.5	Математик, Физик	400	Англи хэл, Нийгэм судлал	400

ШУТИС-ийн бүрэлдэхүүн, харьяа сургуультай хамтарсан хөтөлбөрүүд

д/д	Индекс	Хөтөлбөрийн нэр	Суралцаж жил	Цуглуулах кредит	Суурь хичээл /Аль нэгийг заавал өгсөн байх/		Дагалдах хичээл /Аль нэгийг заавал өгсөн байх/	
					Нэр	Босго оноо	Нэр	Босго оноо

Дархан-уул аймаг дахь Технологийн сургууль

1.	061202	Кибер аюулгүй байдал	1+3	128	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал	410
2.	061303	Мэдээллийн систем	1+3	125	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал	410
3.	071310	Цахилгаан хангамж	1+3	135	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал	410
4.	071501	Механик инженерчлэл	1+3	131	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал	410
5.	073210	Автозамын инженерчлэл	1+3	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал	410
6.	072303	Арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи	1+3	130	Математик, Физик	410	Хими, Англи хэл	410

ШУТИС-ийн харьяа Орхон аймаг дахь “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль

7.	071205	Хаягдал боловсруулах технологи	1+3	130	Математик, Физик	410	Хими, Англи хэл	410
8.	071310	Цахилгаан хангамж	1+3	135	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал	410
9.	071501	Механик инженерчлэл	1+3	131	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал	410
10.	073204	Барилгын инженерчлэл	1+3	130	Математик, Физик	410	Англи хэл, Нийгэм судлал	410

ШУТИС-ийн захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний
өдрийн А/110 дугаар тушаалын хавсралт



ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль								
11.	071402	Үйлдвэрлэлийн автоматжуулалт	1+3	138	Математик, Физик	410	Нийгэм судлал, Англи хэл	410
12.	071601	Авто инженерчлэл	1+3	130	Математик, Физик	410	Нийгэм судлал, Англи хэл	410
13.	073204	Барилгын инженерчлэл	1+3	130	Математик, Физик	410	Нийгэм судлал, Англи хэл	410



ХАВСРАЛТ 3. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

Оролцооны тайлбар: [R] - Хариуцан хийж, гүйцэтгэх; [A] - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; [C] - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрас оролцох; [I] – Алхмын гаралтын мэдээлэл авах

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо (RACI)					
				Э	СБХА	ЭТК	МТТ	БС	ШЗЗ
1	Элсэлтийн журам		ШУТИС-ийн захирлын тушаал		R				A
2	ШУТИС-ийн захирлын тушаал		<ul style="list-style-type: none"> • Элсэгчдэд зориулсан гарын авлага • Элсэлтийн маркетинг, сурталчилгаа • Элсэлтийн веб сайт • Онлайн төлбөр, тооцоо 	I	C	R	C	C	
3	Элсэгчдэд тавигдах шаардлага		<ul style="list-style-type: none"> • Бүртгэлийн хураамж • Элсэхийг хүсэгчдийн бүртгэл 	C	A	R	C	C	I
4	Элсэхийг хүсэгчдийн бүртгэл		<ul style="list-style-type: none"> • Шалгалтын дүн 	C	A	R	C	C	
5	• Элсэхийг хүсэгчдийн бүртгэл • Шалгалтын дүн		<ul style="list-style-type: none"> • Бүртгүүлэгчдийн онооны жагсаалт 		A	R	C		
6	Бүртгүүлэгчдийн онооны жагсаалт		<ul style="list-style-type: none"> • Элсэлтийн veb huudas daahy mdedeel 	I	A	R	C	I	I
7	Элсэлтийн vebийн бүртгэл		<ul style="list-style-type: none"> • Элсэгchidийn burtgeli • 2 bagz cagiyin telbөr • Caхim suralcaх эрхийn bichig 	C	A	R	C	C	I
8	Цахим suralcaх эrхийn bichig		<ul style="list-style-type: none"> • Oyoutny kod 	R	A	C	C	I	
9	Oyoutny kod		<ul style="list-style-type: none"> • Surgaltnyn gerze 	R	C	C	C	A	
10	Surgaltnyn gerze		<ul style="list-style-type: none"> • Элсэлтийн tushaal 		R	C		C	A
11 ¹	Элсэлтийн тушаал		<ul style="list-style-type: none"> • Oyoutny cahim unemplax olgoх 	I	C	C	C	R	A



ХАВСРАЛТ 4. БАЙРШИЛ, ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар холбогдон авна.

ШУТИС-ИЙН УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН ХАЯГ:

Утас:	11-324319
	324590-1021, 324590-1022,
e-mail:	m.erdenetuya@must.edu.mn
Факс:	976-11-318152
Веб хаяг:	http://www.must.edu.mn , http://www.elselt.edu.mn
Шуудангийн хаяг:	ш/х-520, Улаанбаатар-46, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Элсэлтийн комисс
Сургуулийн байршил, хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-8 Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Хичээлийн 1-р байр 212, 213, 217 тоот өрөө

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

Утас:	70374455, 70374735
e-mail:	erdenebold@stda.edu.mn
Факс:	976-37-24455

Сургуулийн байршил, хаяг: Дархан сум. 15 дугаар баг (Шинэ Дархан).

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ОРХОН АЙМАГ ДАХЬ “ЭРДЭНЭТ ЦОГЦОЛБОР” ДЭЭД СУРГУУЛЬ

Утас:	976-035-73421
e-mail:	bolorerdene_d@erdenetmc.mn
Факс:	976-035-73421

Сургуулийн байршил, хаяг: Баян-Өндөр сум. Эрдэнэт хот

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ

Утас:	70534007, 88054166
e-mail:	ichinkhorlood@must.edu.mn

Сургуулийн байршил, хаяг: Даланзадгад сум 3-р баг, Багш хөгжлийн ордон
Өмнөговь аймаг